



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 26 өдөр

Дугаар А/504

Мөрөн сум

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.6, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит XXVIII хуралдааны 37 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн 2024 оны төсвийн хөрөнгөөр сум, агентлаг байгууллагад эрх шилжүүлэн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Дээрх хавсралтад заасан арга хэмжээний зураг төсөл, техникийн тодорхойлолт, ажлын даалгаврыг мэргэжлийн байгууллагаар хянуулан худалдан авах ажиллагааг зохион байгуулж, сонгогдсон гүйцэтгэгчтэй гэрээ байгуулахыг сумын Засаг дарга, холбогдох төсвийн шууд захирагч нарт тус тус даалгасугай.


3. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээр шуурхай зохион байгуулж, үр дүнг тухай бүр цахим системд байршуулж ажиллахыг сум, агентлаг, байгууллагын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Э.Улам-Өсөх)-д даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ



Аймгийн Засаг даргын 2024 оны
09 дүгээр сарын 26-ны өдрийн
А/ХХ захирамжийн хавсралт

АЙМГИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР СУМ АГЕНТЛАГА, БАЙГУУЛЛАГАД ЭРХ
ШИЛЖҮҮЛЭН ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

2024.09.26

Мөрөн сум

Д/д	Худалдан авах бараа, ажил, үйлчилгээний санхүүжилтийн эх үүсвэр, нэр төрөл, тоо хэмжээ хүчин чадал	Хугацаа		Төсөвт өртөг (мян.төг)	Тухайн онд санхүүжих дүн (мян.төг)	Тендер зарлах огноо	Батлагдсан эх үүсвэр	Эрх шилжүүлэн авах сум, байгууллагын нэр
		Эхлэх	Дуусах					
Тод 2.1.5	Рэнчинлхүмбэ сумын төвөөс Жаргант гол хүртлэх зам засвар, арчлалт	2024	2024	20,000.0	20,000.0	2024.09.26 2024.12.15	Замын сан	Рэнчинлхүмбэ сумын ЗДТГ
Тод 2.1.6	Сумын төвийн зам засвар, арчлалт /Рэнчинлхүмбэ сум/	2024	2024	20,000.0	20,000.0	2024.09.26 2024.12.15	Замын сан	Рэнчинлхүмбэ сумын ЗДТГ
Тод 2.1.7	Сумын төвийн зам засвар, арчлалт /Улаан-Уул сум/	2024	2024	20,000.0	20,000.0	2024.09.26 2024.12.15	Замын сан	Улаан-Уул сумын ЗДТГ
Тод 2.1.8	Тоомын даваанаас Өлийн өвдөг хүртлэх зам засвар, арчлалт /Улаан-Уул сум/	2024	2024	20,000.0	20,000.0	2024.09.26 2024.12.15	Замын сан	Улаан-Уул сумын ЗДТГ
Тод 2.1.9	Ханх сумын Тургын /Бөгтөргөл/ давааны авто замын засвар, арчлалт хийх	2024	2024	50,000.0	50,000.0	2024.09.26 2024.12.15	Замын сан	Ханх сумын ЗДТГ
Тод 2.1.4	Дотуур байрны засвар /Бүрэнтогтох сум/	2024	2024	10,000.0	10,000.0	2024.09.26 2024.12.15	ОНХС	Бүрэнтогтох сумын ЗДТГ
Тод 2.1.6	Цэвэр усны машины сав худалдан авах /Цагаан-Уул сум/	2024	2024	19,700.0	19,700.0	2024.09.26 2024.12.15	ОНХС	Цагаан-Уул сумын ЗДТГ

_____ оОо